

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нөхцөл, тавигдах шаардлага, сангийн хөрөнгөөр үнэт цаас болон бусад зөвшөөрөгдсөн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах, хадгалах, бүртгэх, хяналт тавих, хөрөнгө оруулалтын менежментийн гэрээ болон хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан журмын дагуу зөвхөн Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэнэ.

1.3. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих үйл ажиллагааны онцлогтой холбоотой нийтлэг харилцааг Хорооны 2017 оны .. дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар, нарийвчилсан харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаа энэхүү журмаар зохицуулагдахгүй.

Хоёр. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах шаардлага

2.1. Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон энэхүү журамд заасан шаардлага хангасан хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компанид олгоно.

2.2. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компани /цаашид “хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэх/ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.2.1. Компанийн тухай хуульд заасан компанийн хэлбэртэй;

2.2.2. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хөрөнгө оруулалтын санг удирдах болон үнэт цаасыг итгэмжлэлээр удирдах үйл ажиллагаанаас бусад төрлийн үйл ажиллагааг эрхэлдэггүй;

2.2.3. үүсгэн байгуулагч-хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд кастодиан, гэрээт үнэлгээчин болон аудитор байхгүй;

2.2.4. төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн дарга, гишүүнд дараах шаардлага тавигдана. Үүнд:

2.2.4.1. санхүүгийн зах зээл дээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай, энэ чиглэлээр мэргэшсэн байх;

2.2.4.2. энэ журмын 2.2.6.1-т заасан компанид зөрчлийн улмаас тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үед удирдлагад нь ажиллаж байсан бөгөөд тусгай зөвшөөрөл хүчингүй болсноос хойш 3 жил өнгөрсөн байх;